



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 17/61

Чингис хот

Улиралын үр дүнгийн
урамшуулал олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4, 52 дугаар зүйлийн 52.2, "Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2 дугаар зүйлийн 2.1, 2.2, Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын ажил олгогч, ажилчид, үйлдвэрчний хооронд байгуулсан хамтын гэрээний 3 дугаар зүйлийн 3.2, дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2025 оны 1-р улиралын үр дүнг ажлаараа баг, байгууллагынхаа үйл ажиллагаа, зохион байгуулалт, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр санаачилга гарган, ажлын үр дүнгээ сайн биелүүлсэн Засаг даргын орлогч А.Боргил, Тамгын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Лхагвабаатар нарыг 50 хувиар, Хэрлэн багийн Засаг дарга М.Хүрэлчулуун 40 хувиар, Булаг багийн Засаг дарга Б.Отгонбаяр 20 хувиар, Сариг багийн Засаг дарга Ё.Баяртулга 40 хувиар, Өндөрхаан багийн Засаг дарга Б.Мөнх-Эрдэнэ 20 хувиар, Цогт-Өндөр багийн Засаг дарга Д.Мөнхтуяа 40 хувиар тус тус тооцож 1 дүгээр хавсралтад дурдсаны дагуу урамшуулал олгосугай.

2. Тус захирамж гарсантай холбогдуулан холбогдох хууль, тогтоолын дагуу үр дүнгийн урамшуулал бодож олгохыг нягтлан бодогч (Д.Баярцэцэг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Д.ЭРДЭНЭБААТАР

Хэрлэн сумын Засаг даргын 2025 оны
03 дугаар сарын 20-ны өдрийн
дугаар захирамжийн хавсралт 1/61

Төрийн захиргааны удирдах албан хаагч,
Улс төрийн албан хаагчдын урамшуулал

д/д	Албан тушаал	Нэр	Үндсэн цалин	Цалингийн хувь	Дүн
1	Орлогч дарга	А.Боргил	1870000	40%	748000
2	Тамгын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Г.Лхагвабаатар	1283000	50%	641500
3	Хэрлэн багийн Засаг дарга	М.Хүрэлчулуун	1458000	40%	583200
4	Булаг багийн Засаг дарга	Б.Отгонбаатар	1458000	20%	291600
5	Баянмөнх багийн Засаг дарга	Б.Мөнхбаяр	Сануулах сахилга арга хэмжээ		
6	Сариг багийн Засаг дарга	Ё.Баяртулга	1458000	40%	583200
7	Өндөрхаан багийн Засаг дарга	Б.Мөнх-Эрдэнэ	1458000	20%	291600
8	Цогт-Өндөр багийн Засаг дарга	Д.Мөнхтуяа	1458000	40%	583200